

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/04

Өлгий

Г

Г

**Үнэлгээний хороо
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн 2023 онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл, Олон найрлагат бичил тэжээл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга Т.Фестиваль

Гишүүд:

А.Багдат ОНӨГ-ын мэргэжилтэн

Б.Галымбек- Нэгдсэн эмнэлгийн эмийн нягтлан

Б.Тажибек– Иргэдийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

А.Сунхар –Эрүүл мэндийн газрын нарийн бичиг

2. Тендерийн бичиг баримтыг бэлтгэж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг гаргуулж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга /Т.Фестиваль/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН